

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ
ДАРГА Д.ОТГОНСҮРЭН

002000312
ТУЗТИВ А 6292818

**"ЗАМЫН-ҮҮД ХУУРАЙ БООМТ" БАЙГУУЛАХ ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН СУУРЬ СУДАЛГАА БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 04 дугаар сарын 08 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

| | | |
|----|---|---|
| 1. | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах үндэслэл | <ul style="list-style-type: none">- Монгол Улсын Их хурлын 2020 оны 05 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;- Монгол Улсын Их хурлын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого";- Монгол Улсын Их хурлаар 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр;- "Олон улсын¹ чанартай хуурай боомт² байгуулах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоол;- Монгол Улсын тээврийн салбар дахь төрөл бүрийн тээврийн хэрэгслийг нэгтгэн ухаалаг тээврийн системийг хөгжүүлж эдийн засгийн хурдацтай өсөлтийн эрэлтийг хангах замаар эдийн засгийн өсөлтөөс хүртэх боломжийг нэмэгдүүлэх;- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх "Бүс нутгийн логистикийн төв"-ийг түшиглэн эдийн засгийн үр ашигтай, өрсөлдөх чадвартай, найдвартай, холимог тээврийн систем бүхий олон улсын чанаратай хуурай боомт болгон хөгжүүлэх; |
| 2. | Байршил, газар нутгийн хэмжээ, хамрах хүрээ | Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх "Бүс нутгийн логистикийн төв"-ийн 400 га талбай. |
| 3. | Олон улсын чанартай хуурай боомтын чиг үүрэг | Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт тодорхойлсноор олон улсын чанартай хуурай боомтын чиг үүрэг нь: <ul style="list-style-type: none">- Чингэлэг ачаа боловсруулалт, хадгалалт |

¹ "Олон улсын боомт" гэж Монгол Улсын олон улсын гэрээний дагуу иргэний харьяаллыг үл харгалзан зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх боомтыг; Монгол Улсын Хилийн тухай хууль;

² "Боомт" гэж зэрчигч, тээврийн хэрэгсэл, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх зориулалттай, тусгай журмаар зохицуулагддаг нутаг дэвсгэрийг;

Хуурай боомтуудын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт /НҮБ-ын Ази номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (FSCAP);

Хуурай боомт: олон улсын худалдаанд тээвэрлэж буй барааг ажиж буулгах, хадгалах, хяналт шалгалт хийх болон холбогдох гаалийн хяналт, бүрдүүлэлтийг хэрэгжүүлэх нэг буюу түүнээс дээш тээврийн горимоор холбогдсон логистикийн төв болох нутаг дэвсгэрийн дотор байрлах газар

| | | |
|----|--|---|
| 3. | Олон улсын чанартай хуурай боомтын чиг үүрэг | <p>Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт тодорхойлсноор олон улсын чанартай хуурай боомтын чиг үүрэг нь:</p> <ul style="list-style-type: none"> - Чингэлэг ачаа боловсруулалт, хадгалалт - Чингэлэг буулгалт, ачилт - Бөөний ачаа боловсруулалт, хадгалалт - Гаалийн болон бусад хилийн хяналт шалгалт, бүрдүүлэлт - Засвар үйлчилгээ - Тээвэр зууч болон ачаа нэгтгэх үйлчилгээ - Банк даатгал болон санхүүгийн үйлчилгээ - Тээврийн захиалга / зуучлал - Нэмүү өртгийн үйлчилгээ - Удирдлага, зохион байгуулалт ухаалаг WMS /i-WMS/ технологи /ухаалаг логистикийн систем, ухаалаг агуулахын систем, цаг тутмын тээврийн хяналт, борлуулалтыг урьдчилан таамаглах систем, борлуулалтын ухаалаг хураангуй систем/ |
| 4. | Олон улсын чанартай хуурай боомтын бүрэлдэхүүн, хүчин чадал | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаагаар тодорхойлогдоно. |
| 5. | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах хугацаа | 30 хоног |
| 6. | Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгааны иж бүрдэл | <p>Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөгжлийн бодлого, төлөвлөлт, үзэл баримтлал, бүс нутаг хөрш орнуудын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдсан байна.</p> <p>Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгааны тайланд дараах зүйлс багтсан байна. Төслийн онцлогоос хамааруулан судалгааны тайлан нь доорх заалтуудаар хязгаарлагдахгүй.</p> <p>1. “Замын-Үүд хуурай боомт” байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа:</p> <p>Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” нь Замын-Үүд өртөөний нэвтрүүлэх, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт байрлах логистикийн төвүүд, Замын-Үүд эдийн засгийн чөлөөт бүс, Замын-Үүд-Эрээн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийн хөгжлийн шаардлага, хоорондын уялдаа болон ачаа тээврийн дамжин өнгөрүүлэх чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.</p> <ul style="list-style-type: none"> - Замын-Үүд хилийн боомтын тээвэрлэлтийн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх; - Замын-Үүд бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа МЧ-1, МЧ-2, Бүс нутгийн логистикийн төв хоорондын үйл ажиллагааны уялдаа |

| | | |
|--|--|--|
| | | <p>холбооны зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг судлах;</p> <ul style="list-style-type: none">- Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа ачаа, тээврийн хяналт шалгалтын одоогийн үйл ажиллагааны шат дараалал, тулгамдаж буй асуудлуудыг нарийвчлан тодорхойлох;- Олон улсын чанартай хуурай боомт хөгжүүлэх нөхцөл байдлын судалгаа хийх;- БНХАУ-ын Эрээн хилийн боомтын судалгаа, бүс нутгийн логистикийн сүлжээний холболтын судалгааг нарийвчлан хийх;- Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх “Бүс нутгийн логистикийн төв”-ийн үйл ажиллагааны одоогийн барилга, байгууламж, авто зам, талбай дэд бүтцийн хүчин чадал, эх үүсвэр болон хэрэглээг судлан тодорхойлох;- Олон улсын туршлагаар ачаа барааг зөвхөн нэг цэгээс нөгөө цэг рүү ачих бус нэг зангилаа хааб (hub)-аас дараагийн хааб хүртэл холимог тээвэр ашиглан зөөвөрлөх нь ашигтай гэж үзэж байгаа “Замын-Үүд хуурай боомт” -ын бүс нутгийн өрсөлдөх чадвар, хөгжлийн чиглэлийг тодорхойлох;- Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах үе шатыг тодорхойлох /эхний ээлжид шаардлагатай дэд бүтэц, зам талбай тоног төхөөрөмж, хүн хүч гэх.мэт/;- Монгол Улсын гадаад худалдааны өнөө ба ирээдүйн онцлог, худалдааны 10-20 жилийн өсөлтийг тооцоолж хэтийн төлөвийг тодорхойлох;- Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулснаар экспорт, импорт, транзит ачааны хэмжээг нэмэгдүүлэх хүчин зүйлийг тодорхойлох, ачаа тээврийн ойрын болон хэтийн төлөвийг тооцоолох;- Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” -байгуулахад шаардлагатай дэд бүтэц, техник тоног төхөөрөмж зэргийг нарийвчлан судлах;- Далайн боомтуудтай бичиг баримт, мэдээлэл солилцох, хяналт зохицуулалтыг хангасан хяналтын байгууламж, тоног төхөөрөмж, программ хангамжийг нэвтрүүлэх технологийн шийдлийг судлах; |
|--|--|--|

| | | |
|--|--|--|
| | | <ul style="list-style-type: none"> - Орчин үеийн хуурай боомтын үйл ажиллагаанд шаардлагатай зориулалтын тоног төхөөрөмж, алсаас удирдах өндөр хурдны тусгай сүлжээ, автоматажсан хэвтээ болон босоо тээвэрлэлтийн шийдлүүдийн талаар судлах; - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” байгуулагдсанаар олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нийцүүлэн гадаад худалдааг хөнгөвчлөх, гаалийн хяналт шалгалтын хялбарчлах боломжуудыг одоогийн үйл ажиллагааг харьцуулан судлах; - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” байгуулахад гаалийн болон мэргэжлийн хяналтын талаар авах арга хэмжээ, тусгай зөвшөөрлүүдийг тодорхойлох; <p>2. Эдийн засгийн судалгаа, шинжилгээ:</p> <p>Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” -ын Монгол Улсын болон бүс нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдлыг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл - Дэд бүтцийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл - Бүс нутаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл - Хүний хөгжил ба байгаль орчны эрүүл, аюулгүй байдалд үзүүлэх нөлөөлөл - Улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл <p>Ачаа, тээврийн өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлагыг тодорхойлох;</p> <ul style="list-style-type: none"> - Ачаа, тээврийн хэмжээг судлах /Ачаа, тээврийн урсгалын тооцоо/ - Хэтийн төлөвлөлт /Хөрш орнуудын далайн болон хуурай боомтуудын хөгжил, ирээдүйн чиг хандлага/ <p>Хуурай боомтын хөрөнгө оруулалтын ба эдийн засгийн үр ашгийн шинжилгээ</p> <ul style="list-style-type: none"> - Замын-Үүд сумын нутаг дэвсгэр дэх “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт болгон хөгжүүлэх /газар шорооны ба дэд бүтэц/ ажлын зардлын урьдчилсан тооцоолол - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын үе шатны тооцоолол <p>3. Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” байгуулах зөвлөмж:</p> |
|--|--|--|

| | | |
|----|--------------------------------------|---|
| | | <ul style="list-style-type: none"> - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” -ын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах олон улсын сайн туршлагаас судлах, удирдлага бүтэц зохион байгуулалтын хувилбаруудыг тодорхойлох; - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” хөгжлийн үе шат, бизнес хөгжлийн загварын хувилбаруудыг тодорхойлох; - Олон улсын чанартай “Замын-Үүд хуурай боомт” -ыг байгуулах хөрөнгө оруулалт татах үе шатны төлөвлөгөө, хэрэгжүүлэх аргачлал зөвлөмж; |
| 7. | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна. |
| 8. | Онцгой нөхцөл | <ol style="list-style-type: none"> 1. Бүс нутгийн логистикийн төвийн одоогийн үйл ажиллагаа, чингэлэг ачилт буулгалт, хуримтлалыг бууруулах, үйл ажиллагаа тасралтгүй явуулах нөхцөлийг хангах санал шийдэл; 2. Замын-Үүд хилийн боомтын бүс нутгийн тээврийн хөдөлгөөний зохион байгуулалтын одоогийн байдалд дүн шинжилгээ хийж оновчтой санал шийдэл дэвшүүлэх; 3. Бүс нутгийн логистикийн төвийн эдэлбэр газрыг олон улсын чанартай хуурай боомтын үйл ажиллагааны үндсэн чиглэл, технологид нийцүүлэн ашиглалтын зориулалтаар ангилан бүсчлэн хөгжүүлэх санал боловсруулах; 4. Логистик болон хуурай газрын тээврийн чухал хэсэг болох холимог тээврийн³ байгууламжууд (авто зам, төмөр зам, агаарын), эдийн засгийн бүс, аж үйлдвэрийн бүсийн байршил хоорондын холбоосыг бүсийн хэмжээнд тооцож тодорхойлох; 5. Тээврийн системийн техник технологийн шинэчлэл ухаалаг тээврийн систем, тээвэрлэлтийн аргыг төрөлжүүлэх аргуудыг судлан нутагшуулах. Тухайлбал блок трэйн⁴ (block train), шётл трэйн⁵ (shuttle train) зэрэг аргуудыг ашиглан үр ашгийг дээшлүүлэх; 6. Логистикийн холболтын терминал, логистикийн цогцолбор байгуулах зэрэг зам тээврийн жигд |


³ Холимог тээврийн логистикийн төвүүд болон эдийн засгийн бүсүүд нь холимог тээврийн коридорын тусламжтайгаар хоорондоо илүү холбогдож байна.

⁴ Блок трэйн гэдэг нь ачааг илгээгчийн эрэлтийн дагуу нэг зогсоолоос эцсийн зогсоол хүртэл зогсолтгүй ажилладаг түрээсийн галт тэрэг юм. Зогсоолын тоо хязгаартай тул хурдан тээвэр хийх боломжтой.

⁵ Шётл систем нь нэг замтай төмөр замын шугамаар хоёр талдаа явдаг галт тэрэг юм.

| | | |
|--|--|---|
| | | <p>7. Галын аюулгүй байдлаас хамгаалах технологийн горимыг тодорхойлох;</p> <p>8. Хуурай боомтын эрсдэлийн удирдлага буюу яаралтай арга хэмжээний удирдлага зохион байгуулалтын санал;</p> <p>Хууль, эрх зүйн хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> - Гаалийн байгууллагын үр ашгийг дээшлүүлэхэд нөлөөлж буй одоогийн хууль тогтоомжтой холбоотой гацаатай асуудлуудын талаар судалгаа хийж, бодлогын нээлт, инновацын талаар санал гаргах - Олон улсын чанартай хуурай боомтын үйл ажиллагааны онцлогийг тусгасан нэгдсэн бодлого төлөвлөлттэй цогц байдлаар хөгжүүлэх санал дэвшүүлэх; - Монгол Улсад олон улсын чанартай хуурай боомтын хөгжүүлэхэд салбар хоорондын уялдаа зохицуулалтыг хангах асуудлуудыг тодорхойлж шийдвэрлэх зөвлөмж; |
|--|--|---|

ХЯНАСАН:

ХУУРАЙ БООМТ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ӨЛЗИЙБАЯР

ХУУРАЙ БООМТ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
 МЭРГЭЖИЛТЭН  Б.МӨНХБАТ

БОЛОВСРУУЛСАН:

ХУУРАЙ БООМТ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН ХЭЛТСИЙН
 МЭРГЭЖИЛТЭН  Б.ЖАВЗАНПАГМА